33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	132,481.6	0.0	132,481.6
33300	Татаас, санхүүжилтийн авлага	20,585.0	20,585.0	0.0
33400	Зээлийн хүүгийн авлага	6,486.2	0.0	6,486.2
33500	Бусад авлага	684.3	0.0	684.3
33600	Зээлийн авлага	191,725.4	0.0	191,725.4

Аудитын илрүүлэлт:

-Эрүүл мэндийн төв тооцооллын алдаанаас 1921.8 мянган төгрөгийн авлага үүссэнийг данс бүртгэлд тусгаагүй

3.5.2.2 Урьдчилж гарсан зардал

Хүснэгт № 5. Урьдчилж гарсан зардлын дансны үлдэгдлийг байгууллагаар ангилж харуулбал: /мянган төгрөг/

Код:	Байгууллагын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
34	Эрүүл мэндийн төв	300.0	300.0	0.0
	Нийт	300.0	300.0	0.0

Эрүүл мэндийн төвийн урьдчилж гарсан 300.0 мянган төгрөгийн зардал барагдаагүй, он дамжин бүртгэсээр байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материал дансны оны эхний үлдэгдэл 241711.8 мянган төгрөг байсан бол оны эцэст 279030.7 мянган төгрөг болж, 37318.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Бараа материал дансны үлдэгдлийг байгууллагаар харуулбал: /мянган төгрөг/

Код:	Байгууллагын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
35	Хо. Да. Засаг даргын тамгын газар	45,869.1	47,568.1	1,699.0
35	Хо. Да. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	60.0	560.0	500.0
35	Хо. Да. Соёлын төв	7,234.2	7,399.2	165.0
35	Хо. Да. Сургууль	106,488.7	115,079.4	8,590.7
35	Хо. Да. Хүн эмнэлэг	41,523.2	51,519.1	9,995.9
35	Хо. Да. Цэцэрлэг	35,536.6	51,905.0	16,368.4
35	Хо. Да. Орон нутгийн хөгжлийн сан	5,000.0	5,000.0	0.0
	Нийт	241,711.8	279,030.7	37,318.9

Дарви сумын ТТЗ-ийн харьяа байгууллагууд нь тайлан хугацаанд 251413.7 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 826.5 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, 214921.4 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулжээ.

Хүснэгт № 7. Бараа материал дансны өөрчлөлт: /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төсөвт байгууллага, төсөл сан
1	Оны эхний үлдэгдэл	241,711.8
2	Нэмэгдсэн	252,240.2
201	Худалдан авсан	251,413.7
205	Бусад	826.5
3	Хасагдсан	214,921.4
301	Худалдсан, зарцуулсан	214,921.4
4	Эцсийн үлдэгдэл	279,030.7

Аудитын илрүүлэлт:

- Ерөнхий боловсролын сургууль өмнөх оны СТА-аар өгсөн эд хөрөнгийн тооллого, тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, малын нас дэвшилт, өөрчлөлтийн бүртгэл тооцоо хийх албан шаардлага биелүүлээгүй,
- Соёлын төв эд хариуцагчийн тайланд зарим бараа материалыг орлогоор бүртгэж тусгаагүй,

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны оны эхний үлдэгдэл 8453007.2 мянган төгрөг байсан бол оны эцэст 7222525.3 мянган төгрөг болж, 1230481.9 мянган төгрөгөөр буурчээ.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгө дансны өөрчлөлт: /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төсөвт байгууллага
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	8,453,007.2
2	Нэмэгдсэн	469,528.2
201	Худалдан авсан	17,161.0
205	Бусад	452,367.2
3	Хасагдсан	141,216.6
302	Акталсан	141,216.6
4	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	8,781,318.8

6	Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл	-1,315,474.9
801	Элэгдлийн зардал тайлант хугацааны	384,535.2
9	Дансны хасалт	-141,216.6
10	ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЛИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	-1,558,793.4
11	ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГ	7,222,525.3

Тайлант хугацаанд төсвийн санхүүжилтээр 17161.0 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө худалдан авч, 452367.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй болон нэмэлт санхүүжилтийн дансны эх үүсвэрээс худалдан авч, 141216.6 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна. Акталсан хөрөнгийг тодруулбал: Засаг даргын тамгын газар 93893.2 мянга, Эрүүл мэндийн төв 27323.4 мянга, Ерөнхий боловсролын сургууль 20000.0 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох шийдвэрийн дагуу акталж, данс бүртгэлээс хасчээ.

Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийг байгууллагаар ангилбал /мянган төгрөг/

Код:	Байгууллагын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
39	Хо. Да. Засаг даргын тамгын газар	1,265,058.2	1,410,117.3	145,059.1
39	Хо. Да. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.0	500.0	500.0
39	Хо. Да. Соёлын төв	517,856.6	521,820.5	3,963.9
39	Хо. Да. Сургууль	2,559,389.4	2,573,230.0	13,840.6
39	Хо. Да. Хүн эмнэлэг	854,218.1	812,031.0	-42,187.1
39	Хо. Да. Цэцэрлэг	1,941,010.1	1,904,826.6	-36,183.5
	Нийт	7,137,532.3	7,222,525.3	84,993.0

Аудитын илрүүлэлт:

-Ерөнхий боловсролын сургууль өмнөх оны СТА-аар өгсөн эд хөрөнгийн тооллого, тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах албан шаардлага биелүүлээгүй, түүнчлэн зарим эргэлтийн бус хөрөнгийг нэр төрлөөр бүртгэж орлого аваагүй, багц дүнгээр бүртгэсэн.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 6715.4 мянган төгрөг байсан бол оны эцэст 128490.7 мянган төгрөг болж, 121775.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 10. Өр төлбөр дансны үлдэгдлийг байгууллагаар харуулбал: /мянган төгрөг/

Код:	Байгууллагын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
41	Хо. Да. Сургууль	4,092.0	2,850.0	-1,242.0
41	Хо. Да. Хүн эмнэлэг	2,560.1	788.8	-1,771.3
41	Хо. Да. Цэцэрлэг	63.3	370.3	307.0
41	Хо. Да. Орон нутгийн хөгжлийн сан	0.0	124,481.6	124,481.6
	Нийт	6,715.4	128,490.7	121,775.3

Өр төлбөрийн данс материаллаг хэмжээгээр өссөн шалтгаан нь ОНХС-ийн он дамжин хэрэгжих ажлуудын олгогдоогүй санхүүжилтийн дүнгээр өглөг бүртгэсэн байна.

Хүснэгт № 11. Өр төлбөр дансны ангилал: /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төсөвт байгууллага, төсөл сан	Төрийн сан	Устгах бичилт	Нэгтгэсэн нийт дүн
41	Эхний үлдэгдлийн дүн	6,715.4	0.0	0.0	6,715.4
41	Эцсийн үлдэгдлийн дүн : Үүнээс	128,490.7	20,585.0	20,585.0	128,490.7
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	554.0	0.0	0.0	554.0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	605.1	0.0	0.0	605.1
41361	Байгууллагад төлөх өглөг	124,481.6	20,585.0	20,585.0	124,481.6
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,850.0	0.0	0.0	2,850.0

Аудитын илрүүлэлт:

-Эрүүл мэндийн төв тооцооллын алдаанаас 1921.8 мянган төгрөгийн өр төлбөр үүссэнийг данс бүртгэлд тусгаагүй

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын сан дансны эхний үлдэгдэл 7822051.0 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 8801797.0 мянган төгрөг болж, 979745.9 мянган төгрөгөөр есчээ.

Хүснэгт № 12. Цэвэр хөрөнгө, өмчийн байдал:

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,822,051.0	8,801,797.0	979,745.9
51100	Засгийн газрын сан / орон нутгийн сан/	2,709,114.4	2,709,114.4	0.0
51210	Өмнөх үеийн үр дүн	377,091.6	1,817,853.5	1,440,761.9
51220	Тайлант үеийн үр дүн	1,440,970.8	980,209.2	-460,761.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,294,874.2	3,294,619.9	-254.4

Засгийн газрын сан дансанд өөрчлөлт ороогүй, эрүүл мэндийн төвийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс 254.4 мянган төгрөгөөр буурч, өмнөх үеийн үр дүнд 45.5 мянган төгрөгийн залруулга хийгдсэн байна.

3.5.10 Орлогын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлого өмнөх оноос 191980.4 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар буурсан байна.

Хүснэгт № 14 Орлогыг нэр төрлөөр ангилж харуулбал:

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,686,242.0	4,494,261.6	-191,980.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	91,450.4	99,156.6	7,706.2
110	Орлогын албан татвар	73,266.5	86,422.8	13,156.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	73,266.5	86,422.8	13,156.3
113	Хөрөнгийн албан татвар	2,410.0	2,311.0	-99.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	15,773.8	10,422.8	-5,351.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,877,055.4	661,188.6	-1,215,866.8
120	Нийтлэг татварын бус орлого	1,877,055.4	661,188.6	-1,215,866.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,717,736.2	3,733,916.4	1,016,180.2

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд нийт 5183676.9 мянган төгрөгийн орлого тайлагнаж, үүнээс 689415.2 мянган төгрөгийн давхардсан орлогыг устгаж, цэвэр дүнгээр 4494261.6 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлжээ.

Хүснэгт № 15 Орлогыг ангилж харуулбал:

/мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төсөвт байгууллага, төсөл сан	Төрийн сан	Устгах бичилт	Нэгтгэсэн нийт дүн
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,485,776.9	697,900.0	689,415.2	4,494,261.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.0	99,156.6	0.0	99,156.6
110	Орлогын албан татвар	0.0	86,422.8	0.0	86,422.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	0.0	86,422.8	0.0	86,422.8
113	Хөрөнгийн албан татвар	0.0	2,311.0	0.0	2,311.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	0.0	10,422.8	0.0	10,422.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	660,533.6	655.0	0.0	661,188.6
120	Нийтлэг татварын бус орлого	660,533.6	655.0	0.0	661,188.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,825,243.2	598,088.4	689,415.2	3,733,916.4

Татварын бус 661188.7 мянган төгрөгийн орлогын 655.0 мянган төгрөг нь төрийн сангийн татварын бус орлого, 187520.9 мянган төгрөг нь төсөвт байгууллага, төсөл сангийн үйл ажиллагааны орлого, 473012.8 мянган төгрөг нь төсөвт байгууллагын үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө байна.

Хүснэгт № 16 Татварын бус орлогыг төсвийн захирагчдаар ангилж харуулбал: /мянган төгрөг/

Код:	Байгууллагын нэрс	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
12	Хо. Да. Засаг даргын тамгын газар	376,980.8	278,180.8	-98,800.0
12	Хо. Да. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.0	625.0	625.0
12	Хо. Да. Соёлын төв	42,997.8	35,110.0	-7,887.8
12	Хо. Да. Сум хөгжүүлэх сан	2,220.0	1,860.0	-360.0
12	Хо. Да. Сургууль	20,839.2	104,723.4	83,884.2
12	Хо. Да. Хүн эмнэлэг	7,339.4	21,450.8	14,111.4
12	Хо. Да. Цэцэрлэг	1,099,019.3	35,371.8	-1,063,647.5
12	Хо. Да. Орон нутгийн ерөнхий орлого	5,293.7	655.0	-4,638.7
12	Хо. Да. Орон нутгийн хөгжлийн сан	322,365.0	183,211.9	-139,153.1
	Нийт	1,877,055.3	661,188.7	-1,215,866.6

3.5.11 Зардлын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал өмнөх оноос 271558.5 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар өсжээ.

Хүснэгт № 17 Зардлыг ангилж харуулбал: /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,242,493.9	3,514,052.4	271,558.5
21	Урсгал зардал	3,242,493.9	3,514,052.4	271,558.5
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	2,713,691.0	3,402,569.2	688,878.2
213	Урсгал шилжүүлэг	528,802.9	111,483.3	-417,319.6

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгдсэн тайланд нийт 4203467.7 мянган төгрөгийн зардлаас 689415.2 мянган төгрөгийн давхардсан зардлыг устгаж, цэвэр дүнгээр 3514052.4 мянган төгрөгийн зардал тайлагнажээ.

Хүснэгт № 18 Зардлын нэгтгэлийг ангилж харуулбал: /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төсөвт байгууллага, төсөл сан	Төрийн сан	Устгах бичилт	Нэгтгэсэн нийт дүн
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,517,345.1	686,122.6	689,415.2	3,514,052.4
21	Урсгал зардал	3,517,345.1	686,122.6	689,415.2	3,514,052.4
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	3,402,569.2	0.0	0.0	3,402,569.2
213	Урсгал шилжүүлэг	114,775.9	686,122.6	689,415.2	111,483.3

Хүснэгт № 19 Зардлыг төсвийн захирагчдаар ангилж харуулбал: /мянган төгрөг/

Код:	Байгууллагын нэрс	Өмнөх он	Тайлант	Өөрчлөлт
II	Хо. Да. Засаг даргын тамгын газар	436,135.9	535,208.1	99,072.2
II	Хо. Да. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	62,449.2	86,553.0	24,103.8
II	Хо. Да. Соёлын төв	126,118.5	110,497.5	-15,621.0
II	Хо. Да. Сум хөгжүүлэх сан	1,250.0	930.0	-320.0
II	Хо. Да. Сургууль	995,387.6	1,181,738.8	186,351.2
II	Хо. Да. Хүн эмнэлэг	456,862.9	508,065.2	51,202.3
II	Хо. Да. Цэцэрлэг	291,348.0	416,575.2	125,227.2
II	Хо. Да. Орон нутгийн ерөнхий орлого	0.0	9,993.1	9,993.1
II	Хо. Да. Орон нутгийн хөгжлийн сан	355,847.5	664,491.6	308,644.1
	Нийт	2,725,399.6	3,514,052.5	788,652.9

Аудитын илрүүлэлт:

-Сумын Засаг даргын Тамгын газар Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд үлдээж хуримтлуулаагүй

-Төсөвт байгууллагууд бараа ажил үйлчилгээний худалдан авалтын нэхэмжлэх, баримтыг И-баримтаар аваагүй зөрчлүүд түгээмэл байна.

-Хүүхдийн цэцэрлэг нийгмийн даатгалын тайланг буруу, зөрүүтэй тайлагнасан

-Ерөнхий боловсролын сургууль хүнсний бүтээгдэхүүн болон махны гарал үүслийн бичиггүй, дотооддоо хэрэгжүүлэх хяналт сул байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4243033.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4243033.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 306458.0 мянган төгрөгөөр бууруулж 3936575.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Дарви сумын ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 29-ны 07 дугаар тогтоолоор төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн орлогыг 3980995.5 мянга, зардлыг 4243033.1 мянган төгрөгөөр баталсан боловч батлагдсан зардлаас 306458.0 мянган төгрөгөөр хасагдаж, 3936575.1 мянган төгрөгөөр аймгийн нэгдсэн төсөв төлөвлөгөөнд тусгажээ.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 13 хөтөлбөрт зориулан 3936575.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2404989.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 1477056.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 54529.7 мянган төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар төлөвлөжээ.

Аудитын илрүүлэлт:

-Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна. Дээрх зөрчлийн улмаас санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй.

Төсвийн орлого

Дарви сум 3936575.1 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 3294130.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, батлагдсанаас 642444.3 мянган төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна. Үүнд:

Татварын орлогыг 25731.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч нийтлэг татварын бус орлого 32518.0 мянга, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг 620668.0 мянга, тусламж санхүүжилтийн орлого 0.2 мянга, орон нутгийн ерөнхий орлогын дансны оны эхний үлдэгдлээс санхүүжих дүн 14989.4 төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй байгаа нь дараах нөхцөлөөс шалтгаалж байна.

- Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн нэгдсэн системд орон нутгийн ерөнхий орлого, СХС-ийн харилцах дансны үлдэгдлийг орлогын эх үүсвэрт төлөвлөж байгаа боловч НББ-ийн стандарт зарчмын хувьд санхүүгийн тайланд гүйцэтгэлээр тайлагнагдаагүй.
- Төсөвт байгууллагын үндсэн данснаас төвлөрүүлсэн шилжүүлэг нь төсвийн санхүүжилтээс хасагдаж тайлагнагдаж байгаатай холбоотой.

Хүснэгт дугаар 19. Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
-----	----------	------------	-----------	-------

1	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,936,575.1	3,294,130.8	-642,444.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	73,425.4	99,156.6	25,731.2
110002	Үйл ажиллагааны орлого	1,000.0	5,741.4	4,741.4
110003	Хөрөнгийн орлого	40,600.0	44,628.0	4,028.0
110004	Хөрөнгө борлуулсны орлого	0.0	1,170.0	1,170.0
110008	Шууд бус орлого	21,000.0	34,883.3	13,883.3
113002	Бууны албан татвар	2,534.4	2,311.0	-223.4
118001	Улсын тэмдэгийн хураамж	2,156.0	2,671.0	515.0
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,500.0	2,843.2	1,343.2
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,065.0	1,254.0	189.0
118101	Газрын төлбөр	0.0	815.5	815.5
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,070.0	290.0	-780.0
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	2,500.0	2,549.2	49.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,817,693.6	3,164,507.6	-653,186.0
120	Нийтлэг татварын бус орлого	235,268.1	202,750.1	-32,518.0
120003	Торгуулийн орлого	4,000.0	655.0	-3,345.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	231,268.1	202,095.1	-29,173.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,105.0	1,424.0	319.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	167,011.3	200,671.1	33,659.8
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	63,151.8	0.0	-63,151.8
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	3,582,425.5	2,961,757.5	-620,668.0
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,684,199.8	1,648,334.5	-35,865.3
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	1,313,423.0	1,313,423.0	0.0
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	584,802.7	0.0	-584,802.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	30,466.7	30,466.6	-0.2
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,466.7	30,466.6	-0.2
	ОНЕО-ын урьд оны үлдэгдлээс	14,989.4	0.0	-14,989.4
132006	ОНЕО-ын урьд оны үлдэгдлээс	14,989.4	0.0	-14,989.4

Татварын орлого давсан нь 2020 онд сумын иргэдийн Эрдэнэс таван толгой хувьцааны ногдол ашгийн татвар 15654.5 мянган төгрөг шууд бус орлогын дансанд төвлөрсөн нь гол нөлөө үзүүлжээ.

Татварын орлогын ихэнхийг нь нэр төрлөөр давуулан биелүүлсэн боловч бууны албан татвар, ус, рашааны нөөц ашигласны төлбөр хураамжийн орлогууд төлөвлөснөөс тасарсан байна.

Аудитын илрүүлэлт:

-Орон нутгийн төсвийн хүү торгуулийн 290.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан.

-Ерөнхий боловсролын сургууль заалны түрээсийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй,

Төсвийн зарлага

Нийт зардлын 677217.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1313423.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 1684199.8 мянган төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгээс, 30466.7 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 168116.3 мянган төгрөгийг төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогоос, 63151.8 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр төсөвлөснөөс гүйцэтгэлээр ОНХС, ТЗШ, ЭМД-ын сангийн санхүүжилтийг тус тус бүрэн, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 1088.0 мянган төгрөгөөр дутуу авч, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг 33978.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Тайлбар:

1. Тайлант оны эцэст төсвийн шууд захирагчдаас 39437.1 мянган төгрөгийн үлдэгдлийг татан төвлөрүүлсэн нь төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилтээс хасагдсан

2. Сум хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 63151.8 мянган төгрөгийг төсөвт баталсан боловч гүйцэтгэлээр тайлагнах боломжгүй болно.

Хүснэгт №.20. Санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Байгууллагын нэр	Төлөвлөгөө			Гүйцэтгэл			Зөрүү
		Санхүүжилт	Өөрийн орлого, оны эхний үлдэгдлээс	Нийт	Санхүүжилт	Өөрийн орлого, оны эхний үлдэгдлээс	Нийт	
1	ЗДТГ	364,477.4	605.0	365,082.4	365,014.7	924.0	365,938.7	856.3
2	ИТХ	81,328.0	0.0	81,328.0	81,328.0	0.0	81,328.0	0.0
3	Сум хөгжүүлэх сан	0.0	54,529.7	54,529.7	0.0	17,059.2	17,059.2	-37,470.5
4	ОНХСан	1,301,823.0	175,233.4	1,477,056.4	1,301,823.0	183,211.9	1,485,034.9	7,978.5
5	Соёлын төв	80,465.1	500.0	80,965.1	79,186.4	500.0	79,686.4	-1,278.7
	ДҮН	1,828,093.5	230,868.1	2,058,961.6	1,827,352.1	201,695.1	2,029,047.2	-29,914.4
6	ЕБСургууль	1,091,667.9	400.0	1,092,067.9	1,070,668.0	400.0	1,071,068.0	-20,999.9
7	Хүүхдийн цэцэрлэг	364,419.6	0.0	364,419.6	346,045.3	0.0	346,045.3	-18,374.3
8	Эрүүл мэндийн төв	421,126.0	0.0	421,126.0	420,716.4	0.0	420,716.4	-409.7
	ТЗШ-ийн дүн	1,877,213.5	400.0	1,877,613.5	1,837,429.6	400.0	1,837,829.6	-39,783.9
	Нийт сумын дүн	3,705,307.0	231,268.1	3,936,575.1	3,664,781.7	202,095.1	3,866,876.8	-69,698.3

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3050474.3 мянган төгрөг буюу 77.5 хувьтай байгаа нь урсгал зардал 40206.3 мянга, хөрөнгийн зардал 812564.8 мянга, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 33329.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

Хүснэгт дугаар 21. Төсвийн зардлыг ангиллаар харуулбал /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,936,575.1	3,050,474.3	-886,100.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,404,989.0	2,364,782.7	-40,206.3
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	2,344,891.9	2,313,711.3	-31,180.6
213	Урсгал шилжүүлэг	60,097.1	51,071.4	-9,025.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,477,056.4	664,491.6	-812,564.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	54,529.7	21,200.0	-33,329.7

Хүснэгт дугаар 22. Төсвийн зарлагыг байгууллагаар харуулбал /мянган төгрөг/

Код	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
21	Хо. Да. Орон нутгийн хөгжлийн сан	1,477,056.4	664,491.5	-812,564.8
21	Хо. Да. Сум хөгжүүлэх сан	54,529.7	21,200.0	-33,329.7
21	Хо. Да. Засаг даргын тамгын газар	365,082.4	365,938.7	856.3
21	Хо. Да. Хүн эмнэлэг	421,126.0	420,716.3	-409.6
21	Хо. Да. Сургууль	1,092,067.9	1,071,068.0	-20,999.8
21	Хо. Да. Соёлын төв	80,965.1	79,686.4	-1,278.7
21	Хо. Да. Цэцэрлэг	364,419.6	346,045.2	-18,374.3
21	Хо. Да. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	81,328.0	81,328.0	0.0
	Нийт	3,936,575.1	3,050,474.29	-886,100.8

Сумын ОНХС-д 47 төсөл, арга хэмжээнд нийт 1477056.4 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс 664491.5 мянган төгрөгийг 30 төсөл арга хэмжээнд төлөвлөсний дагуу бүрэн зарцуулж, гүйцэтгэл дутуу 3 арга хэмжээний нийт 124481.6 мянган төгрөгийн ажлын санхүүжилтийг олгоогүй авлага, өглөгөөр бүртгэж, 14 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Хүүхдийн цэцэрлэг хоолны хэмнэгдсэн зардлыг төвлөрүүлээгүй, аж ахуйн бусад зардалд зориулалт бусаар зарцуулсан,
- Сумын ЗДТГ Батлагдсан төсвийн зарлагаас 1252.3 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан,
- Сумын ЗДТГ Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна. Дээрх зөрчлийн улмаас санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй,
- Ерөнхий боловсролын сургууль заалны түрээсийн орлогыг хяналтгүй зарцуулсан

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 121024.4 мянган төгрөгийн орлогыг доорх эх үүсвэрээс бүрдүүлж, 74620.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 16105.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулж, 30298.8 мянган төгрөгийг оны эцэст нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орсон 121024.4 мянган төгрөгийн орлогын дийлэнх буюу 59069.6 мянган төгрөг нь сумын Засаг даргын Тамгын газрын, 37075.5 мянган төгрөг нь Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулагджээ.

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,024.4
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,150.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	77,278.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,086.7
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,509.6

Аудитын илрүүлэлт:

- Сумын төсвийн орлого буюу хүү торгуулийн орлогыг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлэн зарцуулсан

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн мэдээлбэл зохих 150 мэдээллээс 102 мэдээллийг хугацаанд нь, 43 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд: Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, аудитын дүгнэлтийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, ОНХС-ийн 1 сараас 10 дугаар сарын мэдээлэл зэргийг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна.

Түүнчлэн сумын Засаг даргын Тамгын газар, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн шилэн дансны мэдээллийн иж бүрэн, ойлгомжтой байдал хангалтгүй байсан учир холбогдох албан тушаалтанд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2800.0 мянган төгрөгийн төлбөрийн акт бүрэн барагдаж, 51180.0 мянган төгрөгийн 5 зөрчлийг арилгах зөвлөмжийн хэрэгжилт 74%-тай байна.

Хүснэгт 24 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, тогтоосон актын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	51180.0	4	51180.0	0	0	74%
Нийт	5	51180.0	4	51180.0	0	0	74%

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс төсвийн 5 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 1 төсөвт байгууллага, 2 төсөл сан, нийт 3 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан гүйцэтгэлээ.

Хүснэгт №25. Аудитад хамрагдсан хэлбэр, аудитын дүгнэлт

№	Байгууллагын ангилал, нэр	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр		Аудитын дүгнэлт		
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг
1	Төсвийн шууд захирагч	ЗДТГ	1			1
2		ИТХ		1		
3		Сургууль	1			1
4		Цэцэрлэг	1		1	
5		ЭМТ	1		1	
6		Соёлын төв	1		1	
7	ОНТС	СХС		1		
8		ОНХС		1		
Дүн			5	3	3	2

Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 3 байгууллагын санхүүгийн тайлан зөрчилгүй, 2 байгууллага хязгаарлалттай дүгнэлттэй баталгаажсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил:

Аудитаар нийт 556477.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 286000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 270477.4 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчилд зөвлөмж өглөө.

Акт, албан шаардлага

Аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид дараах зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

- 2017 онд тариаланчдыг дэмжих зорилгоор Ди Би Эм лизинг ХХК-аас санхүүгийн дамжуулах түрээсийн гурван талт гэрээгээр худалдан авсан 286.0

сая төгрөгийн анхны өртөг бүхий комбайныг данс бүртгэлд хөрөнгө болон өр төлбөрөөр тусгаагүй байтлаа 2020 онд 195.0 сая төгрөгийг сумын орон нутгийн хөгжлийн сан, Хөшөөт хөгжил сангийн эх үүсвэрээс төлбөр барагдуулсан боловч балансад холбогдох бүртгэл тооцоо хийгээгүй, түүнчлэн комбайн ашиглалтад зарцуулж буй хөрөнгө, бүрдүүлж буй орлогын бүртгэл тооцоололд бүртгэлээр хэрэгжүүлсэн хяналт байхгүй зэрэг зөрчил илэрлээ.

2. Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн мэдээлбэл зохих 150 мэдээллээс 102 мэдээллийг хугацаанд нь, 43 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд: Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, аудитын дүгнэлтийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, ОНХС-ийн 1 сараас 10 дугаар сарын мэдээлэл зэргийг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

Төсвийн төвлөрүүлэн захирагчид 270477.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 4 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил

Дарви сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 260797.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 47873.2 мянган төгрөгийн 4 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 212924.7 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 94.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 212830.7 мянган төгрөгийн 16 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт № 26. ТШЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил, шийдвэрлэлт /мянган.төгрөг/

Д/д	Нийт алдаа зөрчил	Нийт алдаа, зөрчил		Үүнээс залруулаагүй						Үүнээс залруулсан	
				Акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ЕБСургууль	4	201,492.8					4	201,492.8		
2	Хүүхдийн цэцэрлэг	3	3,966.3					3	3,966.3		
3	Эрүүл мэндийн төв	4	3,921.8					3	1,921.8	1	2,000.0
4	Сумын ЗДТГ	7	51,123.0					4	5,249.8	3	45,873.2
5	Соёлын төв	3	294.0	1	94.0			2	200.0		
	Нийт дүн	21	260797.9	1	94.0	-	16	212830.7	4	47873.2	

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

ОНХС-ийн авлага, өглөг, бараа материаллын үлдэгдлийн дэлгэрэнгүй бүртгэл, түүнчлэн сумын ОНХС-ийн хөрөнгийг иргэдийн нийтийн хурлаар эрэмбэлэгдсэн ажил, төсөл арга хэмжээнд зарцуулж байгаа эсэхэд хяналт хэрэгжүүлэх нөхцөл боломж бүрдүүлээгүй, холбогдох баримт материалыг ирүүлээгүй учир дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдэл, хүү, алдангийг тооцсон тооцоолол тодорхой бус, түүнчлэн сум хөгжүүлэх сангийн баланс дахь авлагын үлдэгдэл нь сум хөгжүүлэх сангийн программаар тайлагнасан авлага, эксель файлаар тооцоолсон авлагын үлдэгдэл зэрэг нь хоорондоо зөрүүтэй байна.

4.1.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан бүртгэл үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх

4.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох хууль журамд нийцүүлэн сум хөгжүүлэх сангийн зээл олгож эхэлсэн хугацаанаас хойших бүх зээлдэгчдийн мэдээллийг сум хөгжүүлэх сангийн цахим программд зөв бүртгэн оруулж, зээлийн авлага, хүү, алдангийн тооцооллыг дахин нягталж хууль, журмын дагуу үнэн зөв тооцоолон данс бүртгэлд тусгах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4.2 Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангийн зээлийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулсан боловч, холбогдох хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй, түүнчлэн зээлийн авлага төлөвлөсний дагуу бүрэн барагдуулаагүй байна.

4.2.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгө зориулалтын дагуу зарцуулагдахгүй байх, сум хөгжүүлэх сангийн журам зөрчигдөх эрсдэлтэй

4.2.3 Өгсөн зөвлөмж: Сум хөгжүүлэх сангийн зорилго, үйл ажиллагааны журамд нийцүүлэн сангийн хөрөнгийг удирдан зохион байгуулах. Өөрөөр хэлбэл сангийн хөрөнгийг үйлдвэрлэлийг бий болгох томоохон төсөл хөтөлбөрийг түлхүү дэмжих, зээлийн авлагыг хуваарийн дагуу төсөвт төвлөрүүлэх, зээлийн эргэцийг нэмэгдүүлэх, хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах, зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд холбогдох хяналтыг хэрэгжүүлэх талаар зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4.3 Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгүүлэхдээ ажлын гүйцэтгэл, явцын мэдээ, олгосон төсвийн гүйцэтгэлийг хянадаггүй, урьдчилгаа санхүүжилтийг өндөр дүнгээр олгодог, дотоод хяналт хэрэгжүүлдэггүй зөрчил дутагдал түгээмэл байна. Тухайлбал Best buidan house ХК-д 39325.0 мянган төгрөгөөр сумын айл өрхөд эрүүл ахуйн шаардлага хангасан усны сав нийлүүлэх гэрээ байгуулж авсан ба айл өрхөд тараасан жагсаалтаас өөр холбогдох баримт, зураг байхгүй, тооцоо нийлээгүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй зөрчил байна.

4.3.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгө хяналтгүй, үр нөлөөгүй зарцуулагдах. Санхүү, төсвийн холбогдох хууль, журам зөрчигдөх эрсдэлтэй.

4.3.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, ТБОНӨХБАҮХА тухай хууль тогтоомж, холбогдох журамд нийцүүлэн үр нөлөөтэй, зүй зохистой худалдан авалт хийхэд хэрэгжүүлэх санхүү, бүртгэлийн дотоод хяналтыг сайжруулж, холбогдох санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж, зураг, тайлангаар баталгаажуулж хэвших.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

4.4 Төсвийн төлөвлөлт, бүрдүүлэлт, тайлагналтай холбоотой асуудал

4.4.1 Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд төсвийн зарим зардлыг нэр төрлөөр оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн цалин, нийгмийн даатгалын

шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна. Дээрх зөрчлийн улмаас мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй.

4.4.2 Эрсдэл: Төсвийн тухай хууль, журам зөрчигдөх, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

4.4.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу “Төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, тус тус нийцүүлэн харьяа байгууллагуудын төсвийг бодитой төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд зохих зардлын эдийн засгийн ангиллаас зарцуулж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнахад чиглэл өгч, аргазүйгээр хангаж ажиллах. Дээрх зөрчлийг хойшид давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 15-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дарви сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Аудитын код:
2020			ХОА-2021/16/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дарви сумын Засаг дарга		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2017 онд тариаланчдыг дэмжих зорилгоор Ди Би Эм лизинг ХХК-аас санхүүгийн дамжуулах түрээсийн гурван талт гэрээгээр худалдан авсан 286.0 сая төгрөгийн анхны өртөг бүхий комбайныг данс бүртгэлд хөрөнгө болон өр төлбөрөөр тусгаагүй байтлаа 2020 онд 195.0 сая төгрөгийг сумын орон нутгийн хөгжлийн сан, Хөшөөт хөгжил сангийн эх үүсвэрээс төлбөр барагдуулсан боловч балансад холбогдох бүртгэл тооцоо хийгээгүй, түүнчлэн комбайн ашиглалтын үйл ажиллагаанд зарцуулж буй хөрөнгө, бүрдүүлж буй орлогын бүртгэл тооцоололд хэрэгжүүлсэн хяналт байхгүй	286000.0	Албан шаардлага	Засаг дарга, санхүү албаны дарга	О.Ганцоож Б.Эрдэнэгомбо
2	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн мэдээлбэл зохих 150 мэдээллээс 102 мэдээллийг хугацаанд нь, 43 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд: Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, аудитын дүгнэлтийн мөрөөр хийж	-		Засаг дарга, санхүү албаны дарга	О.Ганцоож Б.Эрдэнэгомбо

	хэрэгжүүлсэн ажлын тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, ОНХС-ийн 1 сараас 10 дугаар сарын мэдээлэл зэргийг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна.		Албан шаардлага		
3	Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдэл, хүү, алдангийг тооцсон тооцоолол тодорхой бус, түүнчлэн сум хөгжүүлэх сангийн баланс дахь авлагын үлдэгдэл нь сум хөгжүүлэх сангийн программаар тайлагнасан авлага, эксель файлаар тооцоолсон авлагын үлдэгдэл зэрэг нь хоорондоо зөрүүтэй байна.	198211.6	Зөвлөмж	Засаг дарга, санхүү албаны дарга	О.Ганцоож Б.Эрдэнэгомбо
4	Сум хөгжүүлэх сангийн зээлийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулсан боловч, холбогдох хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй, түүнчлэн зээлийн авлага төлөвлөсний дагуу бүрэн барагдуулаагүй байна.	32940.8	Зөвлөмж	Засаг дарга, санхүү албаны дарга	О.Ганцоож Б.Эрдэнэгомбо
5	ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар ажил гүйцэтгүүлэхдээ ажлын гүйцэтгэл, явцын мэдээ, олгосон төсвийн гүйцэтгэлийг хянадаггүй, урьдчилгаа санхүүжилтийг өндөр дүнгээр олгодог, дотоод хяналт хэрэгжүүлдэггүй зөрчил дутагдал түгээмэл байна. Тухайлбал Best buidan house ХК-д 39325.0 мянган төгрөгөөр сумын айл өрхөд эрүүл ахуйн шаардлага хангасан усны сав нийлүүлэх гэрээ байгуулж авсан ба айл өрхөд тараасан жагсаалтаас өөр холбогдох баримт, зураг байхгүй, тооцоо нийлээгүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй зөрчил байна.	39325.0	Зөвлөмж	Засаг дарга, санхүү албаны дарга	О.Ганцоож Б.Эрдэнэгомбо
6	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд төсвийн зарим зардлыг нэр төрлөөр оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна. Дээрх зөрчлийн улмаас мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан үнэн зөв илэрхийлэгдээгүй.		Зөвлөмж	Засаг дарга, санхүү албаны дарга	О.Ганцоож Б.Эрдэнэгомбо
	ДҮН	556477.4			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР